

## БИЛИГ ХЭМЭЭХ ҮГИЙН ТУХАЙД

С. Дашдэжид \*

Билиг сургаалыг онолын талаас нь сурвалжлан судлахад юуны өмнө “билиг” хэмээх үгийн утга, гарал, түүхэн хэрэглээг тодруулан авч үзэх шаардлагатай юм.

Энэ үгийг монгол хэлнээ наад тал нь 800 жилийн тэртээгээс хэрэглэсээр ирсэн нь нэгэнтээ тодорхой бөгөөд судлаачид эртний түрэг хэлний “bil-” (бил) буюу “мэд-” гэсэн утгатай үйл үгээс үүссэн, монгол хэлэнд ормол үг хэмээн үзэж байна. Өдгөө ч түрэг хэлнүүдэд “бил-мэк”-“мэдэх” гэсэн утгат үгийг өргөн хэрэглэж буй. “bil-” хэмээх үйл язгуурт нэр үг бүтээх “-g” (-г) дагавар залгаж үүссэн “bilig” (билиг) нь түрэг хэлэндээ “мэдлэг, оюун ухаан, болгоомж” (знание, разум, ум, осторожность) [ДНС]<sup>1</sup> хэмээх утгыг илтгэдэг ажээ.

Мөн эл язгуураас *bilgä* “цэцэн” гэсэн утгатай тэмдэг нэр үүсдэг нь ерийн тэмдэг нэрийн хэрэглээнээс гадна язгууртан ноёдын цол болон хэрэглэгдэж байв. Түрэг хэлтний түүхэнд “*bilgä beg*”, “*bilgä čikšän*”, “*bilgä qaγan*”, “*bilgä taluj*”, “*čik bilgä čigši*”, “*inanču bilgä*”, “*kül bilgä qaγan*” зэрэг *bilgä* хэмээх нэр цолтон хаад ноёдын нэр олонтоо гардаг.

Эртний түрэг хэлтнээ бурханы шашин дэлгэрч, ном судар олноор нь орчуулах үест санскрит хэлний ‘*prajñā jñāna*’ (төвдөөр *eши шэйраб* хэмээх зөнгөөр танин мэдэхүйн тухайт ухагдахууныг заасан нэр томъёог “*bilgä bilig*” буюу цэцэн ухаан, цэцэн оюун гэсэн утгаар орчуулсан байдаг. Уйгур хэлээрх Алтангэрэл судраас аван уйгурын эртний бичиг зохиолд *bilgä bilig* хэмээх энэ нэр томъёо олон тохиолддог. Энэ нэр томъёог монголын дуун хөрвүүлэгчид уйгур хэлнээс шууд авч хэрэглэсэн нь бурханы шашны монгол утга зохиолд *билге билге*, *белге билге* гэсэн хоёр янзын бичлэгээр тархжээ. Монгол бичгийн хэлний “бэлгэ билиг” хэмээх уламжлалт нэр томъёо бол бэлгэ тэмдгийн бэлгэ бус, уйгурын “билгэ билиг” хэмээх үг тэр чигээрээ орсон хэрэг гэж үзэлтэй. Харин монгол хэлний “бэлгэ” хэмээх үг буй бүхий, байгаа гэсэн утгат эртний монгол хэлний “бэл” хэмээх үгтэй гарлын хувьд холбоотой болов уу.

Монголын нууц товчоо болон бусад сурвалж бичиг, түрэгийн бичиг соёлын дурсгалуудад “*bilge*” цол хэргэмийн нэрийдэл цөөнгүй байна. Тухайлбал, “МНТ”-нд “*bilge*” гэх үгийг есөн удаа тэмдэглэсэн байна.

47. 1016. ...*caraqai-lingqu-yin kö'ün senggüm-bilge*

\* МХСС, Утга зохиолын тэнхим

<sup>1</sup>) *Древнетюркский словарь*, В.М.Наделяев, Д.М.Насилов и др., Ленинград, 1969, стр 98-100

1017. *ambaqai-tan tayici 'ut oboqтан болу*ba...
52. 1103. *senggüm-bilge-yin kö 'ün ambaqai-qahan qamuq mong=*  
1104. *qol-i meden aba*
142. 4002. *...ong-qan senggüm jaqa-gambu*  
4003. *bilge-beki qurban-I manglai yabu 'ulba...*
177. 5823. *...naiman-u inanca-bilge-qan-tur buru 'utcu oroju 'u-je*
181. 6132. *senggüm anda nadur*  
6133. *elci ilē ilērū bilge-beki tödö 'en qoyar-un nököd-i ilē ke 'ejü*  
6134. *ilēba...*  
6205. *...bilge-beki tödö 'en qoyar qatqulduqui tuq*  
6206. *bosqatqun...*
189. 6526. *...inanca-bilge-qan ügülele 'e*  
6914. *...inanca-bilge-qan ecige cinu*  
6915. *saca nököd-e ere-yin aru aqta-yin qarqam ese üje 'ülüle 'e* [Igor de Rachewiltz, 1972, 21,22, 62, 87, 92, 103] <sup>2</sup>

Мөн “Судрын чуулган”-д “*Чингис хаантай зөрчилдэхийн өмнө Найманы эзэн нь Инанч Билгэ Бүгү хан нэрт байжухуй. Инанч нь итгэх гэсэн итгатай, билгэ нь сүр төгөлдөр цол юм*”<sup>3</sup> [Рашидаддин Фазлуллах, 2013, 97] хэмээн тэмдэглэжээ.

“Монголын нууц товчоо”-ноос өмнөх цаг үеийн хөх түрэгийн хаант улсын үеийн Кул-Тегиний гэрэлт хөшөө ба “Билгэ хаан”-ы хөшөө бичиг, түүнээс ч өмнө бичигдсэн “Хутуг билгэ”-д ч “bilgä” гэх үг хаад ноёдын зэрэг цолны нэрээр тэмдэглэгджээ.

“Билгэ” хэмээх үгийн зэрэгцээ “билиг” хэмээх үгэнд “-т” дагавар залган бүтсэн билигт *ᠪᠢᠯᠢᠭ* гэдэг тэмдэг нэрийг мөн цол өргөмжийн үүргээр хэрэглэж байв. Профессор Г.Намжил “1345 онд бичсэн Цавчаал боомтын зүүн ханын дөрвөлжин үсгийн чулуун сийлмэлд “Өргөн билигт Тү Сү тү Бодисайд сэцэн хаанаар далай улсын амьтныг амруулруун далай буянтны сэцэн номыг дэлгэрүүн... гэжээ. Тү Сү тү Бодисайд хаан өргөн дэлгэр ухаантай, өвөг дээдсийн сургаал айлдварыг мэддэг, хэрэгжүүлдэг учраас “Өргөн билигт” цолыг хүртсэн нь лавтай” [Г.Намжил, 1989, 69]<sup>4</sup> гэж дүгнэсэн нь дээрх саналыг лавшруулж байна. Ийнхүү оюун ухааныг нь үнэлж “Билигт” хэмээн өргөмжлөгдсөн хаадууд монголын түүхэнд цөөнгүй юм. [Юань улсын Тогоонтөмөр ухаант хааны хүү Аюуширидар (1370-1378 онд хаан ор суув)].

“Судрын чуулган”-д “*Чингис хаан: Тэр бас өгүүлрүүн: Хэрэв миний ургийнхнаа хэн нэг нь тогтоосон яса хуулиа зөрчвөл үгээр сургамжилдаг, хэрэв түүнийг дахин зөрчвөл билэгдлийн /билгийн/ дагуу цээрлүүлдэг, харин гурав дахь удаагаа зөрчвөл алс холын нутаг Балжин-Кульжур /хөлчүр/-т явуулаг*” [Рашид-ад-дин, I, 2002, 409]<sup>5</sup> хэмээх

<sup>2</sup>) Igor de Rachewiltz, *Index to The Secret History of the Mongols*, by Indiana University, Bloomington 1972, pp. 21,22, 62, 87, 92, 103.

<sup>3</sup>) Рашидаддин Фазлуллах, *Шашидырын чуулган*, Тэргүүн ботийн дээд дэвтэр, 2013 он, 97-р тал, англи хэлнээс орчуулсан Г.Аким

<sup>4</sup>) Namjil.G, *Činggis qayan-u jasad ba bilig*, Öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1989, 69

<sup>5</sup>) Рашид-ад-дин, *ᠨᠣᠶ᠋ᠳᠤᠢ ᠶ᠋ᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤ*, Нэгдүгээр боть, Орос хэлнээс хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо, УБ, 2002 он, 409-р тал

тэмдэглэл байна. Энд билиг үгийг засагтай адил хууль цаазын ойлголттой бичжээ. Тус бичигт тэмдэглэснээр Чингис хаан тухайн орчин байдалд зохицуулан ярьсан сургаал үгээ билиг хэмээн нэрийдэж тусгай зүйл болгон эмхлэн зассан байна. Энд заасан билиг нь Эзэн хааны сургаал соёрхол, цэцэн мэргэн үгс, зарлиг гэрээсийг хэлэв.

Судлаач Сарангуа монгол билиг сургаалын тухай бүтээлдээ, *Бас “Цагаадай билиг ба гүн утга санаатай үгст бахтай тул” Жалайрдай хүмүүн Гушуг ноёны дэргэд байсан соёл боловсролтой, хэл ам хурц, тархи толгой сэргэлэн нэгэн малчныг бие ойролцоо дуудаж шадар түшмэл болгосон билээ. Тэр малчин Цагаадайд “билиг ба гүн утга санаатай үг” хэлж сонсгож байсан нь лавтай. Энэхүү “билиг” нь энгийн малчин ардын ярьж өгүүлсэн цэцэн мэргэн үгсийг заана. Ийнхүү “билиг” нь эрт үед хаад ноёдын зэрэг цолны нэрийтгэл байсны зэрэгцээ, тэдгээр хүмүүсийн хэлж соёрхсон сургаал соёрхол, малчин ардын өгүүлсэн цэцэн мэргэн үгсийг ч зааж байсан юм [Сарангуа, 2005, 31]<sup>6</sup> гэжээ. Үүнээс үзвэл гагц хаад ноёдын хэлсэн үгс төдийгүй эгэл жирийн ардын гүн утгат цэцэн мэргэн үгсийг “билиг” хэмээн нэрийдэж, эрдэм мэдлэгтэй хүмүүнийг ихэс дээдсийн зэрэгт хүндэтгэн оюун билгээс нь суралцан, үгээр үлгэрлэн сургах уламжлалтай байжээ.*

ХҮП зууны үе болоход “билиг” гэдэг үг нэгэнт сурвалж бичигт олонтаа тэмдэглэдэг болсон байна. ХҮП зууны эхээр бичигдсэн “Алтан хааны тууж”-д “*buyan bilge*” гэдэг үг байхад “Алтан товч”-д

90b 28 erdem-tü bilig-tü-yi olbasu:

90b 29 erdeni ögçü olumlan duran-i inu

90b 30 abubasu açi tusa inu tan

91a 1 -tur yeke bolqu

гэж байхаас гадна

91a 12 bi kemen sedkitele: bilig-iyen

91a 13 *toytaγaydaqui*: [Лувсанданзан, 1990, 90, 91]<sup>7</sup>

гэх мэт бичсэн нь буй.

Толь бичгүүдэд “билиг”-ийг хэрхэн тайлбарласан байдлыг үзвэл,

1. “Хорин нэгтийн тайлбар толь”-д “билиг”-ийг мэдэл хэмээн нэрийдэж “*Мэдэж төсөөлөх илүү, хамгийг багтаан чадахуйг нь мэдэл хэмээнэ*” гэсэн ба мөн “арга билиг”-ийг тайлбарлан “*билиг*” нь *хоёр чанадын нэг ертөнцийн бүрдэлийн ёс* гэж нэрлэжээ [Qorin nigetü tayilburi toli, 1979, 494, 246]<sup>8</sup>. Билигт мэргэшиж шалгарсан, хичээнгүй нямбай гэх мэтийн утгатай болохыг тусгаж байна.
2. “Монгол хэлний тайлбар толь”-д *Оюун ухаан төрөлхийн гарамгай, авьяас; оюун билиг; ухаан билиг төгс* хэмээн тайлбарласан байна [Я.Цэвэл, 1966, 83]<sup>9</sup>.

<sup>6</sup>) Saranyua, *Mongγol bilig surγal-un sudulul*, Begejin Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 2005, 31

<sup>7</sup>) Lubsangdanjin, *Erten-ü qad-un ündüsüleksen törü yosun-u jokiyal-i tobçilan quriγaysan altan tobçi kemekü orusibai*. Orusil biçigsen Ša.Bira, Ulus-un töb nom-un sang-dur qadaγalaydaju bui Lubsangdanjin-u γar biçimel eke-eçe gerel jiruy beledkegsen So.Törübatu, Ulus-un keblel-ün γajar, Ulaγanbayatur, 1990, 90, 91.

<sup>8</sup>) *Qorin nigetü tayilburi toli*, Öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, 1979, 494, 246

<sup>9</sup>) Я.Цэвэл, *Монгол хэлний тайлбар толь*, Улаанбаатар, 1966 он, 83-р тал

3. “Монгол хэлний толь”-д *Оюун ухааны сурч мэдэх хурц чадвар* [Norjin.С., 1999, 965]<sup>10</sup> гэжээ.

Дээрхээс ажиглавал, “билиг” гэх үг нь түрэг хэлний дурсгалт бичгүүдээс уламжлалтай зэрэг цол, нэр хэргэмийг заасан үг. “Билиг” нь оюун, ухаан агаад “арга”-тай нэгдэж, ертөнцийн бүрдэл, бодисын чанар зааж, тусгай нэр томъёо болдог. “Оюун билиг” гэхэд тархи толгой, оюун ухааныг нэрлэж, тэрчлэн оюун тархины хөдөлмөр сургаал заах, өгүүлэл яриаг ч заах болсон. Гэхдээ эртний хаад ноёд, сайд түшмэдийн цэцэн мэргэн үгс, гүн ухаанлаг үгс яриаг “билиг” хэмээн нэрийтгэх мөртөө ардын өгүүлсэн уламжлалт цэцэн мэргэн үгсийг ч зааж байна.

Профессор Г.Мөнх ““билиг” гэдэг бол түрэг гаралтай эхэндээ зэрэг цолны утгатай байж, “хөрш зэргэлдээ улс буюу 12-р зууны үеийн эзэлж авсан соёлт иргэдийн нөлөөнөөс болж, малчин монгол үндэстэн харийн цолыг авч хэрэглэдэг байжээ. Хятадын “ван” буюу “тайж” гэх цолоос гадна тангууд төвдийн “хамбу”, “жаха, хамбу” болон түрэг хэлний “дахин (тахин)”, “билиг” гэх мэт цолыг ч хэрэглэж байсан тухай монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов тэмдэглэсэн зүйлс бий” гээд энэ үгийн олон утгыг дэлгэрэнгүй тайлбарласан байна. (Үүнд, *bilge, bilig* хэмээх хоёр үгийг хутгаж ойлгосон бололтой)

1. “Билиг” гэдэг үг нь билиг, хурц билиг, цэцэн билиг, авъяас билиг мэтийн тархины чадвар, цээжийн цэцийг зааж байна.
2. “Билиг” гэдэг үг нь эрдэм мэдлэг, оюун санаа, гүн билиг, ухаан билиг зэрэг тархины хөдөлмөрийн үр бүтээлийг зааж байгаа юм.
3. “Билиг” гэдгийг “арга” гэдэгтэй хослуулан хэрэглэж, оюун ухааныг зааж байна.
4. “Билиг” гэдэг үг нь нэр төртэй хүмүүсийн соёрхол үг, сургаал, заавар, зарлигийг зааж байна.
5. Арга билиг хосолж байгаль ертөнцийг бүрэлдүүлэх элемент болгон үзжээ.
6. Арга билиг нь гариг бодисын хувирангуй харилцаа, шинж чанарыг илтгэж, хэрэг бодосын улиран хувьсах жам ёсыг заах болжээ” [Г.Мөнх, 1988]<sup>11</sup> гэжээ.

“Билиг сургаал” гэхэд “билиг”-ийн “сургаал соёрхол, цэцэн мэргэн үгс” гэх утгыг товойлгон “сургаал”-тай нэгтгээд хоршоо үг болгон хэрэглэсэн байна. Судлаач Г.Буянбат “Эртний язгуурын үгэнд цэцэн мэргэн хүмүүс буюу аймгийн түрүү, гэрийн ахмад, жич холбогдол бүхий бусад хүмүүсийн зохиосон уран дүрслэг, сургаал үгийг билиг хэмээн нэрлэдэг байжээ. Ингэхлээр билиг ба сургаал хоёр үг нь хоорондоо ижилсээд, билиг сургаал гэх хоршоо үг болсон байна. Гэхдээ билиг сургаал гэдэг нь энгийн хоршоо үг биш, харин нэгэн зүйлийн тогтсон ухагдахуунтай тусгай нэр томъёо болсон байна” гэж оновчтой тодорхойлоод, Монголчуудын дунд “билиг сургаал” гэхээр “Чингисийн билиг сургаал”-ыг хэлж буй хэмээн ташаа ойлгодог. Үнэндээ ганц Чингис хааны айлдсан үгс бус өрлөг жанжид, сайд түшмэл, эрдэмтэн мэргэд, ард иргэдийн уламжилж ирсэн зүйр цэцэн үгсийг шингээн авч бүтсэн нь илэрхий юм. Ялангуяа сүүлд

<sup>10)</sup> Norjin.С., Mang.Mören, *Mongyol kelen-ü toli*, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1999, 965

<sup>11)</sup> *Bilig surgal-Mongyol üндүсүтэн-ü гүн угаан-и оки ётег*, Öbür mongyol-un neyigem-ün sinjilekü uqayan-u setegül, 1988, №3

тэмдэглэсэн нь билиг сургаалд дээрх шинж илүү байна” [ Г.Буянбат, 1985 , 5,8]<sup>12</sup> гэж судалгааны өгүүлэлдээ бичжээ.

Ер нийт ард түмний дунд олон үеийн туршид, ахуй амьдрал, гэр орны хүрээнд их төлөв аман уламжлалаар өргөн тархаж ирсэн сургаалын зохиол бүтээл, аман сургамжийн үгс маш арвин баялаг тул түүнээс шингээн авч бүтсэн билиг сургаалыг тодруулах эсвэл билиг сургаалаас нөлөөлсөн сургамж үгсийг тодотгох шаардлага урган гарч байна. Гэхдээ нэн түрүүнд ардын цэцэн үгст “билиг” хэмээх үг ямар утгатай байгааг шүүж үзлээ.

1. Авьяас билиг, цэцэн билгийг заасан утгатай зүйр үгс:

**Биеийн бөхөөр нэгийг давна**

**Билгийн бөхөөр олныг давна:** Идэр залуу насанд эрч хүчээр нэгийн зэрэг давааг чармайн зүтгэсээр давж чаддаг ч энэ бол амьдралын хэсэгхэн зуурын ид хав. Харин эрдэм боловсролтой, мэдлэг чадвартай ухаан төгөлдөр хүмүүнд олон давааг гэтлэх ид чадал, эрдэм ухаан насан туршид байдаг юм гэсэн ухаарлыг суулган өгчээ.

**Бие байвал хүнд болохгүй юмгүй**

**Билиг байвал эрдэмд болохгүй юмгүй:** Хүний хамгийн чухал зүйл бол эрүүл мэнд. Эрүүл чийрэг хүн ихийг хийж бүтээж чадна гэсэн санаа. Мөн ухаан санаа саруул, оюун ухаан сийрэг, авьяас чадвартай хүмүүн хичээл зүтгэлээр сурахгүй эрдэм, чадахгүй ажил үгүй болохыг хэлжээ.

**Билгийн нүд нь тэгширч**

**Бичгийн үйлс нь дэлгэрэх:** Аливааг ухаарч ойлгох, шүүн тунгаах, нарийн мэдрэмжтэй болж, бичиг номын эрдэм бүхэн нь түгэн дэлгэрэн утга буй.

**Биеийн сүнс биед үгүй**

**Билгийн ухаан цээжинд үгүй:** Өөрийн биед эзэн болохгүй, сурсан мэдсэн зүйлгүй оюун ухаан нь балартан самуурахыг хэлжээ.

**Билигтний ухаан хурц**

**Бачтаны гай их:** Авьяас билигтэй, эрдэм номтой хүний ой ухаан сийрэг, аливааг сурч мэдэхдээ гарамгай бол ов мэх, арга заль, амар хялбар аргаар ажил үйлсийг бүтээдэг хүн бусдад гай тогтор болох нь их хэмээн харшуулжээ.

2. Эрдэм мэдлэг, оюун санааны хүч чадал, хувь хүний хичээл зүтгэлийг үнэлсэн зүйр үгс:

**Мэдэх, сурах урлахад мэргэд багш эрхэм**

**Сонсох, санах, давтахад хичээл билиг эрхэм:** Эрдэм ном сурахад багшаас дуулснаа өөрийн хичээл зүтгэл, уйгагүй хүч хөдөлмөрөөр эрдэм ухаан болгох нь чухал гэсэн утга.

**Омогтой хүний цээжинд билиг тогтох нь бэрх**

**Овгор, товгор газарт ус тогтох нь бэрх:** Уур уцаартай, ааг омогтой, бусдад дээрэлхүү хүн эрдэм номоор тааруухан байдаг адил тэгш бус гадаргууд шингэн зүйл тогтохгүй гэсэн санаа. Эрдэмтэй хүн даруу, их мөрөн дөлгөөн гэсэн зүйр үгтэй адил утгатай.

<sup>12)</sup> Buyenbatu.G, *Mongyol-un erten-ü bilig suryal*, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1985 , 5,8

### **Бие баатар бол нэгэн үеийн баатар**

**Билиг баатар бол түмэн үеийн баатар:** Бие бялдарын чадал тэнхээгээр баатарласан хүн нэг л үедээ баатар. Харин оюун ухаан, эрдэм номоор хэтийдэн сайн үйл бүтээвэл үеэс үед, зуунаас зуунд мөнхрөн төрсөн бие үгүй боловч, үл мартагдахыг өгүүлжээ.

### **Биеэн засахаар**

**Билгээн (ухаанаа) зас эсвэл**

### **Биеэ мэдэж**

**Билгээ нэмж яв:** Гадаад өнгө үзэмж хэсэгхэн зуурын гангараа харин эрдэм ном, оюун ухаан нэгэн насны гангараа тул билиг оюуныг эрхэмлэн эрдэм номдоо хичээн чармайхыг эрт дээр өвөг дээдэс хичээнгүйлэн захиж сургадаг байжээ. Эдээр биеэ чимхээр эрдмээр биеэ чим гэсэн үгтэй утга нэг.

### **Билүүний хүчинд хутга хурц**

**Билгийн хүчинд ухаан хурц:** Хутганы хурц билүүгээр ирлэснийх. Ухааны хурц бол билиг оюун хэр хөгжсөнтэй холбоотой.

### **Биеийг нас иднэ**

**Билгийг мунхаг иднэ:** Орчлонгийн жам ёсоор хүмүүний бие өтөлж хөгшрөх харин мунхагийн хар гайгаар билиг оюун үгүй болно. Шунал тачаал, уур, мунхаг гурваар сэдэгдсэн үйл бүхэн нүгэл болдог.

### **Үг давтвал улиг**

**Ном давтвал билиг:** Олон дахин улиглан давтвал үг үнэ цэнээ алдан улиг болох. Харин эрдэм номыг хичээнгүйлэн мэрийж шамдвал утга учрыг нь бүрэн олж эрдэм мэдлэг арвижих гэсэн утгатай.

### **Эрдэм билиг хичээлээр олдог**

**Энх жаргал тэмцлээр олдог:** Хичээж зүтгэл, мэрийлт чармайлтаар эрдэм ном сурдгийн адил амьдралын олон бартаа саадыг давж сайн сайхан, аз жаргалд хүрнэ.

3. “Билиг” гэдгийг “арга” гэдэгтэй хослуулан хэрэглэж, аливаа бүтэхүй оршихуйн арга үүдэл, мөн чанарыг заасан утгатай зүйр үгс:

### **Арга билгийг эс ухвал**

**Алгандаа бичсэнийг тогтооход бэрх:** Аливаа юмсын зүй тогтол, утга учрыг ойлгож ухаарахгүй бол алган дээр бичсэн мэт ил тодорхой зүйлийг ч ухаж эс чадна. Утга учрыг олж ухаан нь тэлсэн хүн бол үзэж харсан болгоноо тогтоон, ойлгож мэдэхгүй чадахгүй зүйлгүй болох.

Эдгээр зүйр үгээс ажиглахад хүний оюун ухаан, эрдэм чадлыг цар хүрээг нэрлэсэн утга давамгай байна.

“Билиг” хэмээх үг нь оюун ухаан гэсэн үндсэн утгаараа түрэг хэлнээс орсон боловч, ухаан, оюун гэсэн ойролцоо утгат бусад үгээс илүү хүндэтгэлийн утгатай болжээ. Улмаар монгол хэлэнд утга нь өргөжин Чингис хааны болон шадар түшмэл, гавьяатан сайдууд, эрдэмтэн мэргэдийн айлдсан оноч мэргэн үгс, ардын зүйр цэцэн үгс, хожмын хүмүүсийн мэргэн үгс тэргүүтэн сүлэлдэж, утга найруулга нь тэгшрэн нэгэн цогц болсон сургаал, сургамжийн үг хэллэгийг “билиг сургаал” хэмээн нэрлэх болжээ.

## НОМЗҮЙ

1. *Bilig surgal-Mongyol ündüsüten-ü гүн угаан-у оки ёimeг*, Öbür mongyol-un neyigem-ün sinjilekü uqayan-u setegül, 1988, №3
2. Buyenbatu.G, *Mongyol-un erten-ü bilig suryal*, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1985
3. *Древнетюркский словарь*, В.М.Наделяев, Д.М.Насилов и др., Ленинград, 1969
4. *Зүйр сэцэн үгийн зүйлээр хуваасан толь*, УБ 2005. Эмхэтгэн найруулсан Ж.Бат-Ирээдүй
5. Igor de Rachewiltz, *Index to The Secret History of the Mongols*, by Indiana University, Bloomington 1972
6. Lubsangdanjin, *Erten-ü qad-un ündüsülegsen törü yosun-u jokiyal-i tobçilan quriyaγsan altan tobçi kemekü orusibai*. Orusil biçigsen Ša.Bira, Ulus-un töb nom-un sang-dur qadaγalaydaju bui Lubsangdanjin-u γar biçimel eke-eçe gerel jiryγ beledkegsen So.Törübatu, Ulus-un keblel-ün γajar, Ulaγanbayatur, 1990,
7. *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*, Д.Цэрэнсодном, УБ 2011
8. *Монгол зүйр цэцэн үг*. Тэргүүн дэвтэр. УБ 2002. Эмхтгэсэн Г.Ринчэнсамбуу.
9. *Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж*, УБ 1999. Эмхитгэн найруулсан Д.Заяабаатар
10. *Монгол зүйр цэцэн үгийн товч тайлбар толь*. Г.Аким. УБ 2001.
11. *Монгол урианхайн аман зохиол*, Б.Катуу, УБ 2011
12. *Монгол цэцэн үгийн далай*. II, Ж.Дашдорж, УБ 1966
13. Namjil.G, *Çinggis qaγan-u jasaγ ba bilig*, Öbür mongyol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1989
14. Norjin.Ç., Mang.Mören, *Mongyol kelen-ü toli*, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1999
15. Рашид-ад-дин, *Судрын чуулган*, Нэгдүгээр боть, Орос хэлнээс хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо, УБ, 2002 он
16. Saranγua, *Mongyol bilig suryal-un sudulul*, Begejin Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 2005
17. *Торгууд ардын аман зохиол*, Б.Катуу нар, УБ 2002
18. *Qorin nigetü tayilburi toli*, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1979
19. Я.Цэвэл, *Монгол хэлний тайлбар толь*, Улаанбаатар, 1966 он

## SUMMARY

Mongolians have a long tradition to teach and explain their children the ancestor's words, wisdoms and teachings for their education. These words, wisdoms and teachings from not only of Chingis Khan but of his ancestors, descendants, officials, ministers and scholars were called '*bilig surgaal*', which have prevailing meanings as knowledge, spiritual power, talent and diligence.

The word "*bilge*" which has the same etymology as "*bilig*" was a title of "*tsetsen (wise)*" given to khans, lords and nobles who knew the deep meaning of ancestors' words and teachings, and were intellectuals with ability and knowledge to govern.